



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ

АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон,
Сүхбаатарын талбай 6, Утас: 26-70-16, Факс: 32-70-16,
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2016.02.09 № 12

Асуулт тавих тухай


Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Танд дараах асуултыг тавьж байна.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн төрийн өмчлөлийн 51 хувийг зээлийн баталгаанд гарган “Жаст групп” ХХК нь Өмнөд Африкийн “Стандарт” банкнаас зээл авсан байх бөгөөд уг компани зээлээ хугацаандаа төлж чадаагүйгээс “Стандарт” банк Лондонгийн арбитрайн шүүхэд хандаж нэхэмжлэл гаргасан, улмаар арбитрайн шийдвэр нэхэмжлэгчийн талд гарч “Эрдэнэт үйлдвэр” ХХК нь зээлийн батлан даагчийн хувьд 99 сая ам.доллар төлөхөөр болсон гэсэн мэдээлэл гарч байна.

Иймд “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн 51 хувийг баталгаанд гаргаж Өмнөд Африкийн “Стандарт” банкнаас “Жаст групп” ХХК-аас хэчнээн хэмжээний зээл авсан, уг үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явагдсан эсэх, баталгаа гаргасан холбогдох албан тушаалтнууд хууль зүйн хувьд эрхтэй байсан эсэх, Өмнөд Африкийн “Стандарт” банкнаас олгосон зээл “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн гадаад улс дахь дансанд орсон эсэх болон хэрхэн зарцуулсан, уг зээлтэй холбогдуулж олон улсын шүүхийн байгууллагаас ямар шийдвэр гарч, хэрхэн хэрэгжиж байгаа талаар дэлгэрэнгүй хариулт өгөхийг Танаас хүсье.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэгт заасан хугацаанд өгөхийг Танаас хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Х.Н.Нямбаатар Х.Н.НЯМБААТАР

Т.АЮУРСАЙХАН

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.ЭНХБАЯР

Л.ЭНХБОЛД